



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/350

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, иргэн Цогтгэрэлийн Амарбат /РЮ85030316/-ын хүсэлтийг үндэслэн Мөрөн сумын 7 дугаар баг Далайван сургуулийн ар талд байршилтай 6712016403 нэгж талбарын дугаартай 24м², 6712014293 нэгж талбарын дугаартай 35м², 6712008885 нэгж талбарын дугаартай 29м² автомашины гаражийн зориулалттай газруудыг нэгтгэж нийт 89м² газрыг үлдсэн 8 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/38 дугаар захирамжийн хавсралтын 9 дэх заалт, 2021 оны 08 дугаар сарын 03-ний өдрийн А/361 дүгээр захирамжийн хавсралтын 6 дахь заалт, 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/194 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 1 дэх хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

3. Газар эзэмшиж байгаа иргэн Ц.Амарбаттай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН